# ГОВЬ ФИНАНС ББСБ ХХК

## Санхүүгийн тайлан болон
## Хараат бус аудиторын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31

ГОВЬ ФИНАНС ББСБ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2022 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

---


| **АГУУЛГА** | **ХУУДАС** |
|---|---|
| ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ | |
| ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | |
| САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН | 1 |
| ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН | 2 |
| ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН | 3 |
| МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН | 4 |
| САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД | 5-13 |

ГОВЬ ФИНАНС ББСБ ХХК

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

---

| | |
|---|---|
| ӨМЧИЙН ХЭЛБЭР: | Хувийн өмч |
| УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР: | 9015002066 |
| РЕГИСТРИЙН ДУГААР: | 5605881 |
| АЛБАН ХАЯГ: | Говь Финанс ББСБ ХХК<br>Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,<br>1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө,<br>Гурван гал оффис, 411 тоот |
| КОМПАНИЙН УДИРДЛАГА: | Гүйцэтгэх захирал – Г.Зулаа<br>Ерөнхий нягтлан бодогч – Б.Баттогтох |
| АУДИТОР: | Ниямазон Аудит ХХК<br>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,<br>2 дугаар хороо, Чоймболын гудамж,<br>Нийслэлийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны<br>байр, 406 тоот |

ГОВЬ ФИНАНС ББСБ ХХК

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Говь Финанс ББСБ ХХК-ийн (цаашид ББСБ гэх) Гүйцэтгэх захирал Ганбатын Зулаа болон Ерөнхий нягтлан бодогч Бат-Амгалангийн Баттогтох, бид энд хавсаргасан санхүүгийн тайлан нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн, Сангийн Яамнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн болохыг батламжилж байна.

Санхүүгийн тайлан бэлтгэхэд удирдлага дараах хариуцлагыг хүлээнэ:

- Нягтлан бодох бүртгэлийн зохих зарчмуудыг сонгож, тууштай мөрдөх;
- Үндэслэл бүхий үнэлгээ тооцоолол хэрэглэх;
- СТОУС-ын шаардлагыг мөрдөх;
- Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компани нь ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн төсөөллийг баримтлах.

Мөн удирдлага нь санхүүгийн тайлантай холбоотой дараах үүргийг хүлээнэ.

- Үр өгөөжтэй, найдвартай дотоод хяналтын системийг боловсруулж, нэвтрүүлж, үйл ажиллагааг нь хангах;
- Компанийн санхүүгийн байдлын тухай үнэн зөв илэрхийлэх мэдээллийг ямар ч үед илэрхийлэх нягтлан бодох бүртгэлийн системийг ажиллуулж, санхүүгийн тайлангаа СТОУС-ын шаардлагад нийцүүлэх;
- Нягтлан бодох бүртгэлийг Монгол улсын зохих хууль тогтоомжийн дагуу хөтлөх;
- Өөрийн эрх үүргийн хүрээнд компанийн хөрөнгийг бүрэн бүтэн байлгах арга хэмжээг авах;
- Алдаа, зальт ажиллагаа болон бусад хууль бус ажиллагааг илрүүлж, урьдчилан сэргийлэх.

УЛААНБААТАР ХОТ
ГОВЬ ФИНАНС ББСБ ХХК
9022110365
5605881 СБА11053

ГАНБАТЫН ЗУЛАА
(Гүйцэтгэх захирал)

БАТ-АМГАЛАНГИЙН БАТТОГТОХ
(Ерөнхий нягтлан бодогч)

Улаанбаатар хот, Монгол Улс
2023 оны  дугаар сарын

Ниямазон Аудит ХХК
Улаанбаатар хот, Чингэлтэй дүрэг,
2 дугаар хороо, Чоймболын гудамж,
Нийслэлийн үйлдвэрчний эвлэлүүдийн
холбооны байр, 406 тоот

**Санхүүгийн Тайлангийн Аудитын Тайлан**

**Дүгнэлт**

Бид "Говь Финанс ББСБ" ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусвар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх "Говь Финанс ББСБ" ХХК-ийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусвар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу үнэн, бодитой илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол Улсын Аудитын тухай хуулийн шаардлагын дагуу компаниас хараат бус байж бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

**Санхүүгийн тайланд хүлээх удирдлагын үүрэг хариуцлага**

Санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу залилан болон алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэхэд шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага нь компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх ба нөлөөлөх асуудлыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

**Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан болон алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууриас хандаж, мэргэжлийн итгэл үнэмшил бүхий үнэлэлтийг хийдэг. Бид мөн:

- Залилан болон алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, тохирох аудитын горимыг боловсруулж, дүгнэлтийн үндэслэл болохуйц нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэгтэй холбоотой үүсдэг тул алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Компанийн үйл ажиллагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг талуудын хооронд байгуулсан аудитын ажлын гэрээт захидалд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчид зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.




З.Цээнээ
Захирал
Ниямазон Аудит ХХК
2023 оны 02 дугаар сарын 03

2022 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| | Тодруулга | 2021 мян.төг | 2022 мян.төг |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 3 | 1,089,215 | 960,814 |
| Зээл (Цэвэр) | 4 | 6,978,993 | 8,887,048 |
| Бусад авлага | 5 | 1,471,195 | 1,434,023 |
| Бусад хөрөнгө | 6 | 721,633 | 201,001 |
| Үндсэн хөрөнгө | 7 | 169,233 | 130,568 |
| Биет бус хөрөнгө | 8 | 650,000 | 620,000 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | **11,080,269** | **12,233,454** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 9 | 1,909,502 | 2,276,359 |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | 10 | 4,273,200 | 3,954,992 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **6,182,702** | **6,231,351** |
| **ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| Энгийн хувьцаа | 15 | 3,238,270 | 3,238,270 |
| Хуримтлагдсан ашиг | | 1,659,297 | 2,763,833 |
| **НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ** | | **4,897,567** | **6,002,103** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | **11,080,269** | **12,233,454** |

НИЯМАЗОН АУДИТ ХХК БАТАЛГААЖУУЛАВ

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

2022 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

| | Тодруулга | 2021 мян.төг | 2022 мян.төг |
|---|---|---|---|
| Хүүгийн орлого | 11 | 2,521,063 | 3,773,494 |
| Хүүгийн зардал | | 417,353 | 293,377 |
| **Хүүгийн цэвэр орлого** | | **2,103,710** | **3,480,117** |
| Хүүгийн бус орлого | 12 | 39,414 | 80,382 |
| Хүүгийн бус зардал | 13 | 568,722 | 1,561,874 |
| **Цэвэр хүүгийн бус орлого (зардал)** | | **(529,307)** | **(1,481,492)** |
| Болзошгүй эрсдлийн зардал | | 664,546 | 710,889 |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)** | | **909,856** | **1,287,736** |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | | - | - |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 14 | 14,188 | 36,573 |
| **Ердийн үйл ажиллагааны ашиг (алдагдал)** | | **895,668** | **1,251,163** |
| Ердийн бус орлого | | - | - |
| Ердийн бус зардал | | - | - |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | | **895,668** | **1,251,163** |
| Орлогын татварын зардал | | 90,986 | 146,626 |
| **Цэвэр ашиг (алдагдал)** | | **804,682** | **1,104,537** |

НИЙМАЗОН АУДИТ ХХК
БАТАЛГААЖУУЛАВ

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

2022 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| | Энгийн хувьцаа мян.төг | Хуримтлагдсан ашиг мян.төг | Нийт эздийн өмч мян.төг |
|---|---|---|---|
| 2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 3,238,270 | 854,614 | 4,092,884 |
| Тайлант үеийн цэвэр ашиг | - | 804,682 | 804,682 |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - |
| **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **3,238,270** | **1,659,296** | **4,897,566** |
| Тайлант үеийн цэвэр ашиг | - | 1,104,537 | 1,104,537 |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - |
| **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **3,238,270** | **2,763,833** | **6,002,103** |

НИЯМАЗОН АУДИТ ХХК
БАТАЛГААЖУУЛАВ

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

2022 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| | 2021 мян.төг | 2022 мян.төг |
|---|---|---|
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| Зээлийн хүүгийн орлого | 2,913,085 | 3,510,917 |
| Харилцах дансны хүүгийн орлого | - | - |
| Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого | 291 | - |
| Гадаад валютын ханшийн зөрүү | 178 | 60,984 |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | - | 600 |
| Хүүгийн орлогын буцаалт | - | - |
| Бусад үйлчилгээний орлого | 640,817 | - |
| **Үндсэн үйл ажиллагааны нийт мөнгөн орлого** | **3,554,371** | **3,572,501** |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал | 417,353 | 293,377 |
| Үндсэн ба нэмэгдэл цалин | 259,106 | 213,492 |
| Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал | 66,553 | 56,933 |
| Албан томилолт, сургалтын зардал | 3,952 | 14,534 |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | 40,819 | 63,816 |
| Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | 35,307 | 46,072 |
| Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал | 6,197 | 5,138 |
| Татвар, даатгалын төлсөн мөнгө | 42,825 | 45,374 |
| Зар сурталчилгаанд төлсөн мөнгө | 4,495 | 4,204 |
| Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө | 32,137 | 141,653 |
| Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө | 3,748 | 10,770 |
| Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө | 3,840 | 4,312 |
| Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө | 2,767,299 | 2,617,130 |
| Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө | 659,191 | 891,708 |
| **Үндсэн үйл ажиллагааны нийт мөнгөн зарлага** | **4,342,820** | **4,408,513** |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(788,449)** | **(836,012)** |
| **ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| Бусад орлого | - | 734,785 |
| Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал | 11,326 | 21,215 |
| Торгуулийн зардал | - | 240 |
| Бусад зардал | 2,862 | 5,719 |
| **Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(14,188)** | **707,611** |
| БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (802,637) | (128,401) |
| МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ | 1,891,852 | 1,089,215 |
| **МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | **1,089,215** | **960,814** |

ШИНЭЛЭГ АУДИТ ХХК
БАТАЛГААЖУУЛАВ

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## 1. Компанийн талаар мэдээлэл

Говь Финанс ББСБ ХХК нь 2012 оны 8 дугаар сарын 8-нд Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх 1/255 тоот тусгай зөвшөөрөл авсан байна. Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2016 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 84 дүгээр тушаалаар түс ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 401.0 сая төгрөгнөөс 631.0 сая төгрөг, 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 93 дугаар тушаалаар 888.0 сая төгрөг, 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 181 дүгээр тушаалаар 1,060.0 сая төгрөг, 2018 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 464 дүгээр тушаалаар 2,276 сая төгрөг, 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 154 дүгээр тушаалаар 3,238.3 сая төгрөг болгон нэмэгдүүлснийг баталсан байна.

Улсын бүртгэлийн дугаар: 9015002066
Регистрийн дугаар: 5605881
Хувь нийлүүлэгч: 1

Үйл ажиллагааны чиглэл:
- Санхүү зээл
- Факторингийн үйлчилгээ
- Төлбөрийн баталгаа гаргах
- Гадаад валютын арилжаа

Компанийн үндсэн үйл ажиллагаа явуулдаг албан хаяг нь Гурван гал оффис, Чингисийн өргөн чөлөө, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс.

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

### Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Компанийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу түүхэн өртгөөр бүртгэх тогтсон зарчмыг баримтлан бэлтгэгдсэн ба энэ зарчим нь бодит үнэ цэнээрх тодорхой санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнэ болон бодит үнэ цэнийн үнэлгээн дээр үндэслэн санхүүгийн анхлан хүлээн зөвшөөрөх өөрчлөлтийг тусгасан. Компани өөрийн санхүүгийн байдлын тайланг хөрвөх чадварын дарааллаар толилуулдаг. Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг дор толилуулав. Өөрөөр заагаагүй санхүүгийн тайлагналын хугацааны туршид эдгээр бодлогыг тогтмол баримталдаг.

### Тайлангийн мөнгөн тэмдэгт

Эдгээр санхүүгийн тайлангуудыг барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг эдийн засгийн анхдагч орчны мөнгөн тэмдэгт буюу үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлсэн.

### Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд түргэн хөрвөх боломжтой, үнэ цэнээ алдах эрсдэл багатай хэрэгсэл хамаарна. Касс болон банкны харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламж, 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан, үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацаатай хөрөнгө оруулалт хамаарна. Эдгээр хөрөнгийг нэрлэсэн үнээр бүртгэнэ.

### Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа

ББСБ нь зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцохдоо зээлийн багцыг бүлгийн болон тусгай үнэлгээний ангилалд хуваж үздэг. Үнийн дүн том эсвэл төлөгдөх хугацаа нь их хугацаагаар хэтэрсэн зээлийн авлагуудыг тусгай үнэлгээний ангилалд оруулан, үнэ цэнийн бууралтыг нь хэмжинэ. Бусад зээлүүд нь бүлгийн үнэлгээний ангилал руу ангилагдана. Тусгай үнэлгээний ангилалд буй зээлийн авлагад үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг тогтоохдоо авлагуудын төлөгдөх хугацаа нь хэтэрсэн эсэхийг нэн түрүүнд харгалзана. Мөн үнэ цэнийн бууралтыг үүсгэх нөхцөл байдал үүссэн эсэхийг шалгаж, тэдгээр нь хөрөнгийн ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлсөн эсэхийг харгалзана.

**Зээлийн эрсдэлийн сан**

Санхүүгийн зохицуулах хорооны дарга болон Сангийн сайдын хамтарсан 2015 оны 144/125 дугаар тушаалаар баталсан "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу зээлийн эрсдэлийн санг байгуулдаг. Эрсдлийн санг актив тус бүрийн үлдэгдэл дүнгээс:

- хэвийн ангилалд 0 хувь
- хугацаа хэтэрсэн ангилалд 5 хувь
- чанаргүй ангилалтай актив, үүнээс хэвийн бус ангилалд 25 хувь, эргэлзээтэй ангилалд 50 хувь, муу ангилалд 100 хувь

**Бусад авлага**

Бусад байгууллага, хувь хүн, холбоотой талд өгсөн нэг хүртэлх жилийн хугацаатай буюу үйл ажиллагааны нэг циклийн дотор эргэн төлөгдөх зээл, үндсэн үйл ажиллагаатай холбогдолгүй үүссэн бусад авлага хамаарна.

**Бараа материал**

Компанийн бараа материалд бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх бичиг хэргийн материал болон хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа хөрөнгө орно. Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь үнэлнэ.

**Урьдчилж төлсөн зардал, тооцоо**

Тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлагыг (даатгал, түрээс г.м) санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулж, урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зарлагыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ. Бараа материал, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна.

**Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгө ба тоног төхөөрөмжийг анхны өртгөөр нь бүртгэнэ. Тайлант хугацаа бүрийн эцэст үндсэн хөрөнгө ба тоног төхөөрөмжийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хорогдол болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тусгадаг. Хөрөнгийг олж эзэмшихтэй холбоотой гарсан зардлыг өртөгт шингээнэ. Худалдан авсан тоног төхөөрөмжийн ажиллагааны салшгүй хэсэг болох программ хангамжийг холбогдох тоног төхөөрөмжийн хамт капиталжуулна.

**Биет бус хөрөнгө**

Биет бус хөрөнгө гэж биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөн бус хөрөнгийг хэлнэ. Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдол, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь толилуулна.

**Богино хугацаат өр төлбөр**

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны циклийн хэвийн нөхцөлд төлбөр нь төлөгдөхөөр хүлээгдэж байгаа эсхүл тайлангийн өдрөөс хойш 12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг богино хугацаат өр төлбөрөөр бүртгэнэ.

**Дансны өглөг**

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны явцад бэлтгэн нийлүүлэгчдээс худалдан авсан бараа, хангамжийн зүйлс, үйлчилгээний үнийн төлөгдөөгүй үлдэгдэл хамаарна.

**Татварын өр**

Тайлант үеийн татвар гэдэгт тайлант үеийн татвар ногдуулах ашиг (алдагдал)-аас тооцсон орлогын албан татварын өглөгийн дүн болон хойшлогдсон татварын өглөг эсвэл хойшлогдсон татварын хөрөнгөөс бүрддэг. Тайлант жилийн татвар нь тухайн жилийн орлогоос хуулийн дагуу тогтоосон татварын хувиар ногдуулсан татварын өглөгийн дүн юм.

**Богино хугацаат зээл, хүүгийн өглөг**

Нэг жилээс доош хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийн дүнг энэ хэсэгт толилуулна.

**Урт хугацаат зээл**

Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийн дүнг энэ хэсэгт толилуулна.

**Эзэмшигчдийн өмч**

Эзэмшигчдийн өмч буюу капитал нь оруулсан капитал болон олсон капиталын нийлбэр юм. Эзэмшигчдийн өмч нь ББСБ-ын нийт хөрөнгийн дүнгээс өр төлбөрийг хассан дүнтэй тэнцүү байна.

Оруулсан капитал нь аливаа хугацаанд капитал өмчийн хувьцаанд төлсөн буюу өөр ямар нэг байдлаар бизнест ашиглахын тулд хувьцаа эзэмшигчдийн ББСБ-д оруулсан хөрөнгийн нийт дүнг хэлнэ. Оруулсан капиталд эргэлтэнд байгаа өмчийн хувьцааны нэрлэсэн үнэ, гаргалтын аливаа хөнгөлөлтийг хассан цэвэр урамшуулал, захиалгын гэрээгээр төлсөн дүн зэрэг зүйлс багтана.

Олсон капитал нь ББСБ ашигтай үйл ажиллагаа явуулсны үр дүнд нэмэгдсэн капитал. Энэ нь тухайн ББСБ-ын хуваарилагдаагүй нийт орлого юм.

Хувьцаа нь ББСБ-д хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн, санал өгөх, ногдол ашиг авах, ББСБ-ыг татан буулгахад түүний эд хөрөнгөөс тодорхой хэсгийн өмчлөх эрхийг гэрчилж буй үнэт цаас. Хувьцаат капитал нь худалдагдсан хувьцааны нэрлэсэн үнийн дүн.

Нэмж төлөгдсөн капитал нь хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн хэмжээг хэлнэ. Хувьцааг нэрлэсэн үнээс доогуур үнээр борлуулбал хүлээсэн алдагдлыг нэмж төлөгдсөн капиталын дансанд сөрөг тэмдэгтэйгээр харуулна.

**Хуримтлагдсан ашиг**

Хуримтлагдсан ашиг нь үйл ажиллагаа эхэлсэн үеэс нэмэгдсэн капитал юм. Энэ нь тухайн тайлангийн хугацаанд олсон цэвэр ашгийн хэмжээгээр нэмэгдэж, алдагдлын хэмжээгээр буурна.

**Үндсэн үйл ажиллагааны орлого**

Үндсэн үйл ажиллагааны орлого нь хугацаандаа байгаа ба хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн, харилцах, хадгаламжийн дансны хүүгийн, үнэт цаасны, хугацаандаа байгаа ба хугацаа хэтэрсэн факторингийн үйлчилгээний хүүгийн, гадаад валютын ханшийн тэгшитгэлийн, үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн, гадаад валютын арилжааны, үнэт цаасны арилжааны, итгэлцлийн үйлчилгээний, мөнгөн гуйвуулгын ба үйлчилгээний хураамж, шимтгэлийн болон хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгсний хураамжийн орлого зэргээс бүрдэнэ.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг дотор нь (1) хүүгийн, (2) хүүгийн бус орлого, (3) бусад гэж ангилна. Хүүгийн орлого нь тодорхой гэрээний үндсэн дээр зээлдэгчдэд олгосон зээл, бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгөд тэдгээрийг ашиглуулсны төлөө авч буй хариу төлбөр юм. Хүүгийн орлогыг нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бүртгэнэ.

## 3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

| | 2021 мян.төг | 2022 мян.төг |
|---|---|---|
| Бэлэн мөнгө | 1,019,283 | 835,208 |
| Банкинд буй мөнгө | 67,798 | 123,029 |
| Банкинд буй хадгаламж | 2,134 | 2,577 |
| | **1,089,215** | **960,814** |

Мөнгөн хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, харилцах дансан дахь мөнгөнөөс бүрдэж байгаа бөгөөд ямар нэгэн хязгаарлалт хийгдээгүй.

## 4. ЗЭЭЛ (ЦЭВЭР)

| | 2021 мян.төг | 2022 мян.төг |
|---|---|---|
| Хэвийн зээл | 6,619,105 | 8,752,543 |
| Хугацаа хэтэрсэн зээл | 378,829 | 141,584 |
| Чанаргүй зээл | 427,527 | 460,519 |
| **Нийт зээл** | **7,425,461** | **9,354,646** |
| Зээлийн эрсдэлийн сан | (446,468) | (467,598) |
| **Зээлийн цэвэр үлдэгдэл** | **6,978,993** | **8,887,048** |
| | | |
| Чанаргүй зээл: | | |
| Хэвийн бус зээл | 206,891 | 313,800 |
| Эргэлзээтэй зээл | 7,194 | 719 |
| Муу зээл | 213,442 | 146,000 |
| | 427,527 | 460,519 |

Нийт зээлийн үлдэгдэлд хэвийн зээлийн үлдэгдэл 93.56 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1.51 хувь, чанаргүй зээлийн үлдэгдэл 4.93 хувийг тус тус эзэлж байна.

## 5. БУСАД АВЛАГА

| | 2021 мян.төг | 2022 мян.төг |
|---|---|---|
| Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага | 867,433 | 1,130,010 |
| Бусад авлага | 603,762 | 304,013 |
| | **1,471,195** | **1,434,023** |

## 6. БУСАД ХӨРӨНГӨ

| | 2021 мян.төг | 2022 мян.төг |
|---|---|---|
| Урьдчилж төлсөн зардал, тооцоо | 715,367 | 193,177 |
| Бусад бараа материал | 6,266 | 7,824 |
| | **721,633** | **201,001** |

## 7. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

| | Тавилга эд хогшил мян.төг | Компьютер, дагалдах хэрэгсэл мян.төг | Тээврийн хэрэгсэл мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|---|
| **Өртгөөр** | | | | |
| 1-р сарын 1-нээр | 31,156 | 86,849 | 159,000 | 277,005 |
| Нэмэгдсэн | 4,894 | 1,060 | - | 5,954 |
| Хасагдсан | 4,230 | - | 9,500 | 13,730 |
| 12-р сарын 31-нээр | 31,820 | 87,909 | 149,500 | 269,229 |
| **Хуримтлагдсан элэгдэл** | | | | |
| 1-р сарын 1-нээр | 13,388 | 62,821 | 31,562 | 107,771 |
| Тайлант онд байгуулагдсан | 3,041 | 16,204 | 14,950 | 34,196 |
| Хасагдсан | 1,644 | - | 1,662 | 3,306 |
| 12-р сарын 31-нээр | 14,785 | 79,025 | 44,850 | 138,661 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх дансны үнэ** | **17,035** | **8,884** | **104,650** | **130,568** |

## 8. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

| | 2021 мян.төг | 2022 мян.төг |
|---|---|---|
| Програм хангамж | 650,000 | 650,000 |
| Хуримтлагдсан хорогдол | - | (30,000) |
| | **650,000** | **620,000** |

## 9. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

| | 2021 мян.төг | 2022 мян.төг |
|---|---|---|
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл | 1,139,520 | 1,377,840 |
| ЭМД, НДШ-ийн өглөг | 10,987 | 17,361 |
| ААНОАТ өглөг | 158,995 | 281,158 |
| Бусад өглөг | 600,000 | 600,000 |
| | **1,909,502** | **2,276,359** |

## 10. УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

| | 2021 мян.төг | 2022 мян.төг |
|---|---|---|
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл | 4,273,200 | 3,954,992 |
| | **4,273,200** | **3,954,992** |

## 11. ХҮҮГИЙН ОРЛОГО

| | 2021 мян.төг | 2022 мян.төг |
|---|---|---|
| Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого | 2,519,071 | 3,772,875 |
| Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого | 1,704 | 620 |
| Харилцах дансны хүүгийн орлого | - | - |
| Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого | 291 | - |
| Хүүгийн орлогын буцаалт | (3) | - |
| | **2,521,063** | **3,773,495** |

## 12. ХҮҮГИЙН БУС ОРЛОГО

| | 2021 мян.төг | 2022 мян.төг |
|---|---|---|
| Гадаад валютын арилжааны орлого | - | - |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого | 2,799 | 61,104 |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | - | 600 |
| Бусад үйлчилгээний орлого | 36,615 | 18,678 |
| | **39,414** | **80,382** |

13. ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ

| | 2021 мян.төг | 2022 мян.төг |
|---|---|---|
| Үндсэн болон нэмэгдэл цалингийн зардал | 319,554 | 264,523 |
| Түрээсийн зардал | 40,819 | 63,816 |
| Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | 38,365 | 64,195 |
| Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал | 37,338 | 33,185 |
| Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал | 32,174 | 141,653 |
| Харилцаа холбоо, интернет | 27,189 | 36,301 |
| Автоматжуулалттай холбоотой урсгал зардал | 27,014 | 24,032 |
| Шатахуун болон тээврийн зардал | 5,170 | 6,855 |
| Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа | 4,495 | 4,204 |
| Сургалтын зардал | 3,952 | 3,892 |
| Зохицуулалтын хураамжийн зардал | 3,840 | 4,312 |
| Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ | 3,748 | 10,770 |
| Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ | 3,288 | 2,917 |
| Ариун цэврийн зардал | 3,013 | 1,543 |
| Бичиг хэргийн зардал | 2,470 | 2,817 |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал | 1,552 | 847,448 |
| Захиалгат хэвлэлийн зардал | 713 | 883 |
| Хууль, өмгөөллийн зардал | 4,928 | 100 |
| Албан томилолт | - | 10,643 |
| Бусад зардал | 9,100 | 37,785 |
| | **568,722** | **1,561,874** |

14. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ

| | 2021 мян.төг | 2022 мян.төг |
|---|---|---|
| Баяр, ёслолын зардал | 11,048 | 21,102 |
| Торгууль, алдангийн зардал | - | 240 |
| Хөрөнгө данснаас хассаны гарз | - | 9,399 |
| Зочин төлөөлөгчийн зардал | 277 | 113 |
| Бусад | 2,862 | 5,719 |
| | **14,188** | **36,573** |

15. ЭНГИЙН ХУВЬЦАА

| | 2021 мян.төг | 2022 мян.төг |
|---|---|---|
| Хувьцаа эзэмшигч "Говь Бизнес Финанс" ХХК | 3,238,270 | 3,238,270 |
| | **3,238,270** | **3,238,270** |

16. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Үзүүлэлт | Зохистой харьцаа | 2022 он | Тайлбар |
|---|---|---|---|
| Өөрийн хөрөнгө, активын харьцаа: | | | |
| 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө ба эрсдлээр жигнэсэн активын харьцаа | >10% | 48.6% | Хангасан |
| Нийт өөрийн хөрөнгө ба эрсдлээр жигнэсэн активын харьцаа | >20% | 48.6% | Хангасан |
| 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө ба нийт активын харьцаа | >10% | 49.1% | Хангасан |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | >8% | 42.2% | Хангасан |
| Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | <30% | 13.2% | Хангасан |
| Үндсэн хөрөнгө, активын зохистой харьцаа | <15% | 1.1% | Хангасан |
| Гадаад валютын эрсдэл | | | |
| Нийт валютын хувьд | +/- 40% | 8% | Хангасан |

| | Хугацаагүй мян.төг | 1 сар хүртэл мян.төг | 1-6 сар мян.төг | 6-12 сар мян.төг | 12 сараас дээш мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | | | | |
| Бэлэн мөнгө | 835,208 | - | - | - | - | 835,208 |
| Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах | 123,029 | - | - | - | - | 123,029 |
| Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж | 2,577 | - | - | - | - | 2,577 |
| Зээл | - | - | 3,022,477 | - | 6,332,169 | 9,354,646 |
| Хөрөнгө оруулалт | - | - | - | - | - | - |
| Факторинг | - | - | - | - | - | - |
| Авлага | - | - | - | - | 304,013 | 304,013 |
| Бусад актив | 201,001 | - | - | - | - | 201,001 |
| **НИЙТ САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ** | **1,161,815** | **-** | **3,022,477** | **-** | **6,636,182** | **10,820,474** |
| **Өр төлбөр** | | | | | | |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | - | - | - | - | - | - |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл | - | - | - | 1,377,840 | 3,954,992 | 5,332,832 |
| Бусад эх үүсвэр | - | - | - | - | - | - |
| **НИЙТ САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** | **-** | **1,377,840** | **3,954,992** | **5,332,832** |
| Цэвэр зөрүү | 1,161,815 | - | 3,022,477 | (-1,377,840) | 2,681,190 | 5,487,642 |
| Цэвэр зөрүү (өссөн дүнгээр) | 1,161,815 | 1,161,815 | 4,184,292 | 2,806,452 | 5,487,642 | 5,487,642 |
| Нийт хөрөнгийн дүн | 12,233,454 | 12,233,454 | 12,233,454 | 12,233,454 | 12,233,454 | 12,233,454 |
| **Хөрөнгө, өр төлбөрийн зөрүүг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа** | **9%** | **9%** | **34%** | **23%** | **45%** | **45%** |